



ЗООНОЗЫН ӨВЧИН СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ

2024 оны 02 сарын 08 өдөр

Дугаар 8/09

Улаанбаатар хот

Г Байгууллагын тусламж, үйлчилгээний
шуурхай бэлэн байдлыг хангах тухай

Монгол Улсын Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3, Хөдөлмөрийн тухай хуулийн 97 дугаар зүйлийн 97.1.2, Эрүүл мэндийн сайдын 2019 оны А/36 дугаар тушаал, Эрүүл мэндийн сайдын 2023 оны 1а/545 тоот албан бичиг, Эрүүл мэндийн хөгжлийн төвийн 130 тоот албан бичиг, Төвийн Хөдөлмөрийн дотоод журмын 3 дугаар бүлгийн 3.1.16, 5 дугаар бүлгийн 5.1.3, 5.1.10 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Монгол түмний уламжлалт Цагаан сарын баярын амралтын өдрүүдэд зоонозын халдварт өвчний дуудлагын бэлэн байдал, байгууллагын хэвийн үйл ажиллагааг ханган ажиллах, дуудлагад үйлчлэх баг, хариуцлагатай жижүүр, хяналт тавих албан тушаалтны нэрсийг хавсралтаар баталсугай.

2. Амралтын өдрүүдэд зоонозын халдварт өвчний дуудлагын бэлэн байдал, хариу арга хэмжээг тухай бүр шуурхай зохион байгуулах, байгууллагын цахилгаан, дулаан, аюулгүй байдалд хяналт тавьж, үүсч болохуйц эрсдэлүүдээс сэргийлэх, мэдээ мэдээллийг төвийн удирдлагуудад тухай бүр мэдээлэх, өдөр бүрийн 09:00-10:00 цагт тухайн өдрийн мэдээллийг Эрүүл мэндийн сайдын 2019 оны А/611 дүгээр тушаалын АМ-36 маягтын дагуу тусгайлан бэлтгэж, хянуулан Эрүүл мэндийн хөгжлийн төвд хүргүүлэн ажиллахыг Дуудлага хяналтын бага эмч, хариуцлагатай жижүүрүүдэд тус тус үүрэг болгосугай.

3. Цаг үеийн байдалтай холбоотой, яаралтай шийдвэрлэх асуудал, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдал, зоонозын халдварт өвчний яаралтай дуудлага гарсан үед төвийн захирал болон холбогдох албаны дарга наарт шуурхай мэдээлж, хариу арга хэмжээг зохион байгуулж ажиллахыг Дуудлага хяналтын баг, дуудлага хяналтын жижүүрүүдэд тус тус даалгасугай.

4. Яаралтай дуудлагын үед шаардагдах багаж, халдварт хамгааллын хувцас хэрэгсэл, утасны карт, шатахуун, тослох материал, цахилгааны нэмэлт эх үүсвэрээр хангах, гал түймэр, аваар ослоос урьдчилан сэргийлэх, аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгч автомашинуудын бэлэн байдлыг хангаж ажиллахыг Санхүү, хангамж, нөөцийн албаны дарга (Д.Болдбаатар)-д хариуцуулсугай.

5. Эрүүл мэндийн яам болон Эрүүл мэндийн хөгжлийн төвөөс гаргасан холбогдох тушаал, шийдвэр болон энэхүү тушаалыг нийт ажилтнуудад танилцуулж, илүү цагаар ажилласан бүртгэл тооцоог хийж, баталгаажуулан ажиллахыг Хүний нөөцийн менежер (Э.Пагмадулам)-т даалгасугай.

6. Ажлын өрөөний хаалгыг журмын дагуу лацдан, түлхүүрийг дуудлага хяналтын бага эмчид хүлээлгэн өгөх, гар утсаа нээлттэй байлгах, үүрэг гүйцэтгэж буй ажилтан ажлын байрыг орхиж явах, согтууруулах ундаа хэрэглэх зэрэг зөрчил гаргахгүй сахилга, хариуцлагатай байхад онцгой анхаарах, шаардлагатай тохиолдолд мэдээлэл өгснөөс 1 цагийн дотор ажлын байранд цуглан ажиллахыг Нийт бүрэлдэхүүнд үүрэг болгосугай.

7. Өдөр тутмын үйл ажиллагаа болон хариуцлагатай жижүүрээр ажилласан эмч, мэргэжилтнүүдийг удирдлагаар ханган, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргааны албаны дарга (Э.Номин)-д даалгасугай.

ЗАХИРЛЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ХАВСРАН ГҮЙЦЭТГЭГЧ



Б.АМГАЛАНБАЯР

Зоонозын ёвчин судлалын үндэсний төвийн
Захирлын албан үүргийг хавсралт гүйцэтгэгчийн
2024 оны 02 дугаар сарын 08...-ны өдрийн
109 дугаар тушаалын хавсралт

TT35150 № 9092005

БАЯР АМРАЛТЫН ӨДРҮҮДЭД АЖИЛЛАХ ХУВААРЬ

| № | Албан тушаал | Нэрс | Утасны дугаар | ТАЙЛБАР | | | |
|--|---------------------------------------|---|----------------------|---|--|--|--|
| Дуудлагад үйлчлэх баг | | | | | | | |
| 1. | Тархвар судлагч | Ш.Сувд-Эрдэнэ | 89972818 | 2 дугаар сарын 10-13-нд дуудлагад үйлчилнэ. /2 дугаар сарын дуудлагын баг/ | | | |
| 2. | Нян судлагч | Б.Батжаргал | 99183172 | | | | |
| 3. | Генетикч | Б.Нацагдорж Н.Даваажав | 88071648 80013700 | | | | |
| 4. | Лаборант | Д.Отгонсүрэн | 80800310 | | | | |
| 5. | Эмнэл зүйч эмч | Н.Отгонбаяр | 86070288 | | | | |
| 6. | Малын эмч | С.Отгонжаргал | 88000686 | | | | |
| 7. | Ариутгагч | Г.Алтанцэцэг | 88202019 | | | | |
| 8. | Бэлтгэмэлч | Б.Уганчимэг | 88556202 | | | | |
| 9. | Дуудлагын түргэн тусламжийн жолооч | Ч.Лхагвасүрэн | 99753973 | | | | |
| Дуудлага хяналтын бага эмч | | | | | | | |
| 1. | Дуудлага хяналтын бага эмч | Я.Ягаанхүү | 99217139 | 2 сарын 10-нд | | | |
| 2. | | Г.Алтанзул | 99980449 | 2 сарын 11-нд | | | |
| 3. | | П.Шийлэгбат | 99665644 | 2 сарын 12-нд | | | |
| 4. | | Я.Ягаанхүү | 99217139 | 2 сарын 13-нд | | | |
| Хариуцлагатай жижүүр | | | | | | | |
| 1. | Албаны дарга | Л.Роломжав | 88050228 | 2 сарын 10-нд | | | |
| 2. | Албаны дарга | У.Өнөрсайхан | 99149780 | 2 сарын 11-нд | | | |
| 3. | Албаны дарга | У.Нармандах | 99148824 | 2 сарын 12-нд | | | |
| 4. | Тасгийн эрхлэгч | Х.Цэрэнсүрэн | 80151719 | 2 сарын 13-нд | | | |
| 5. | Аж ахуйн менежер О.Сансар-89104700 | Байгууллагын аюулгүй байдлыг хангах, гэнэтийн гамшиг, осол, тог цахилгаан, ус дулааны эрсдэл үүссэн тохиолдолд үйл ажиллагааг хэвийн явуулах арга хэмжээ яаралтай зохион байгуулах. Гар утсыг байнга нээлттэй байлгаж, дуудлага авах бэлэн байдлыг хангах, шаардлагатай тохиолдолд хэрэглэх багаж хэрэгслийн нөөцийг бэлтгэх. | | | | | |
| 70282853 дугаартай утсаар 24 цагийн турш иргэдэл мэдээлэл зөвлөгөө өгнө | | | | | | | |
| Хариуцлагатай жижүүрүүд 16:00 цагт ЭМХТ-ийн 70128801 дугаарын утсанд холбогдох байгууллагын цаг үеийн мэдээллийг өгнө. | | | | | | | |

ЗООНОЗЫН ӨВЧИН СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВ